



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Асгат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ЗАА-2026/087/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2026 он



Төрийн Аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatar@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Оюунсүвд

Утас: 99076038

Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn

Гэрээт аудитор : Ц.Алтантуул

Утас: 91195554

Цахим хаяг: tuul9565@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Улаангай сум, Завхан аймаг 81090
Утас/Факс: 7046-36-12
Цахим шуудан: zavkhan@audit.gov.mn

2026.02.13 № 031

Тайлан № _____

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Асгат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Асгат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Асгат сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд урсгал үйл ажиллагааны санхүүжилтээс 1,433.0 сая төгрөгийн, орон нутгийн төсвийн санхүүжилтээр 250.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Асгат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан тодруулгуудад дүгнэлт өгөх аудитаар бараа материал дутагдуулсан, эд хөрөнгийн тооллогыг хуулийн дагуу хийж гүйцэтгээгүй зөрчил илэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 23.0 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 30.0 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж, бүртгэлд тусгасан байна. Шилэн дансыг цахим системд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг оруулаагүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д. БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	204,547,889.90	68,855,661.90
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	112,983,179.43	20,055,774.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	112,983,179.43	20,055,774.00
3121	Төгрөг	112,983,179.43	20,055,774.00
31211	Төрийн сангийн харилцах	112,983,179.43	20,055,774.00
33	АВЛАГА	30,144,341.37	8,073,403.70
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	30,144,341.37	8,073,403.70
35	БАРАА МАТЕРИАЛ	61,420,369.10	40,726,484.20
351	Түүхий эд материал	310,000.00	320,000.00
35110	Тусгай зориулалттай материал	310,000.00	320,000.00
354	Хангамжийн материал	61,110,369.10	40,406,484.20
35410	Бичиг хэргийн материал	4,426,952.00	6,043,386.00
35420	Аж ахуйн материал	4,591,939.20	5,314,039.20
35430	Сэлбэг хэрэгсэл	350,600.00	350,600.00
35460	Хүнсний материал	17,953,626.61	4,137,054.00
35470	Бусад хангамжийн материал	24,561,405.00	24,561,405.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	784,671,038.52	799,431,733.37
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	784,671,038.52	799,431,733.37
392	Биет хөрөнгө	759,482,871.73	774,298,566.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	599,217,690.00	599,217,690.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(67,506,519.64)	(77,563,481.20)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,000,000.00	14,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(14,000,000.00)	(14,000,000.00)

39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	260,029,872.33	241,511,205.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	(74,145,375.33)	(63,046,790.18)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	65,086,551.10	73,800,190.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	(38,359,287.73)	(27,283,649.07)
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,208,482.91	751,413.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	(7,208,482.91)	(751,413.50)
39217	Ном	15,159,941.00	27,663,401.00
393	Биет бус хөрөнгө	25,188,166.79	25,133,166.79
39301	Програм хангамж	1,820,000.00	1,820,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,865,833.21)	(1,920,833.21)
39303	Бусад биет бус хөрөнгө	25,234,000.00	25,234,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	989,218,928.42	868,287,395.27
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	78,428,200.00	56,440,160.87
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	78,428,200.00	56,440,160.87
413	Өглөг	78,428,200.00	56,440,160.87
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	191,550.87
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	13,967,200.00	13,036,860.00
4136	Бусад өглөг	64,461,000.00	43,211,750.00
41361	Байгууллагад төлөх өглөг	64,461,000.00	43,211,750.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	625,519,210.15	811,847,234.40
51	Засгийн газрын хувь оролцоо	625,519,210.15	811,847,234.40
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	285,271,518.27
51101	Өмч: - төрийн		285,271,518.27
512	Хуримтлагдсан үр дүн	114,336,127.95	15,392,633.93
51210	Өмнөх үеийн үр дүн	114,336,127.95	106,058,722.28
51220	Тайлант үеийн үр дүн	-	(90,666,088.35)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	511,183,082.20	511,183,082.20

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	703,947,410.15	868,287,395.27
---	--	----------------	----------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,638,965,636.00	1,725,699,380.66
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	119,136.00	45,434,580.66
120	Нийтлэг татварын бус орлого	119,136.00	45,434,580.66
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	45,434,580.66
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,904,900.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	42,529,680.66
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,638,846,500.00	1,680,264,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,404,004,000.00	1,430,025,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,404,004,000.00	1,430,025,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	234,842,500.00	250,239,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	234,842,500.00	250,239,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,501,853,625.38	1,837,408,353.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,501,853,625.38	1,837,408,353.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,407,971,991.52	1,766,033,255.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,017,039,359.48	1,221,049,319.31
210101	Үндсэн цалин	654,546,474.50	710,747,178.39
210102	Нэмэгдэл	300,081,394.98	414,807,815.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	27,620,000.00

210104	Урамшуулал	62,411,490.00	67,874,325.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	131,553,314.43	144,634,701.84
210201	Тэтгэврийн даатгал	84,540,684.64	100,371,578.75
210202	Тэтгэмжийн даатгал	10,144,775.35	12,090,300.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,569,387.65	6,444,990.56
210204	Ажилгүйдлийн даатгал	4,454,237.94	5,118,915.80
210205	Эрүүл мэндийн даатгал	17,844,228.85	20,608,916.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	168,381,916.14	174,364,401.75
210301	Гэрэл, цахилгаан	5,038,919.91	5,430,043.70
210302	Түлш, халаалт	162,302,896.23	168,055,358.05
210303	Цэвэр, бохир ус	1,040,100.00	879,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,426,290.00	13,346,108.00
210401	Бичиг хэрэг	3,999,800.00	10,203,508.00
210402	Тээвэр, шатахуун	6,291,790.00	3,142,600.00
2105	Нормативт зардал	34,758,775.00	103,579,032.61
210502	Хоол, хүнс	34,758,775.00	103,579,032.61
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,998,300.00	360,000.00
210604	Урсгал засвар	3,998,300.00	360,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,485,239.40	11,112,234.15
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,278,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,485,239.40	8,833,434.15
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,328,797.07	97,587,457.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,115,750.00	48,775,587.29
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,843,047.07	48,811,870.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	93,881,633.86	71,375,098.25

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	71,375,098.25
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	71,375,098.25
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>137,112,010.62</u>	<u>(111,708,973.19)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>137,112,010.62</u>	<u>(111,708,973.19)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31
/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	=	<u>1,683,169,700.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	2,904,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	2,904,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	2,904,900.00
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,904,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	1,680,264,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	1,430,025,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,430,025,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	250,239,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	250,239,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	=	<u>1,776,097,105.43</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,776,097,105.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	1,665,775,257.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	1,201,409,283.67

210101	Үндсэн цалин	-	682,294,863.50
210102	Нэмэгдэл	-	399,039,674.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	27,198,833.02
210104	Урамшуулал	-	92,875,912.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	150,058,854.61
210201	Тэтгэврийн даатгал	-	102,081,411.01
210202	Тэтгэмжийн даатгал	-	12,000,357.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	5,999,678.80
210204	Ажилгүйдлийн даатгал	-	5,995,141.44
210205	Эрүүл мэндийн даатгал	-	23,982,265.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	174,364,401.75
210301	Гэрэл, цахилгаан	-	5,430,043.70
210302	Түлш, халаалт	-	168,055,358.05
210303	Цэвэр, бохир ус	-	879,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	4,898,500.00
210402	Тээвэр, шатахуун	-	4,898,500.00
2105	Нормативт зардал	-	52,005,950.00
210502	Хоол, хүнс	-	52,005,950.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	4,500,000.00
210604	Урсгал засвар	-	4,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	12,266,526.15
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,278,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	9,987,726.15
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	66,271,741.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	61,939,741.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	4,332,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	110,321,848.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	38,946,750.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	38,946,750.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	71,375,098.25
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	71,375,098.25
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	(92,927,405.43)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	(92,927,405.43)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		112,983,179.43

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	285,271,518.27	511,183,082.20	114,336,127.95	910,790,728.42
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	285,271,518.27	511,183,082.20	114,336,127.95	910,790,728.42
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(108,657,065.45)	(108,657,065.45)
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	285,271,518.27	511,183,082.20	5,679,062.50	802,133,662.97

D0 1	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	285,271,518.2 7	511,183,082.20	5,679,062.50	802,133,662.97
D0 2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(8,277,405.67)	(8,277,405.67)
D0 3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	285,271,518.2 7	511,183,082.20	(2,598,343.17)	793,856,257.30
D0 8	Тайлант үеийн үр дүн	-	-	(90,666,088.35)	(90,666,088.35)
D0 9	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	285,271,518.2 7	511,183,082.20	(93,264,431.52)	703,190,168.95

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	1,680,264,800.00	1,680,264,800.00	
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,680,264,800.00	1,430,025,300.00	250,239,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,680,264,800.00	1,430,025,300.00	250,239,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого			
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		250,239,500.00	-250,239,500.00
132001	Орон нутгийн төсвөөс		250,239,500.00	-250,239,500.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,904,900.00	2,904,900.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,904,900.00	2,904,900.00	

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,683,169,700.00	1,683,169,700.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,738,282,201.75	1,776,097,105.43	-37,814,903.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,695,624,901.75	1,665,775,257.18	29,849,644.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,218,876,300.00	1,201,409,283.67	17,467,016.33
210101	Үндсэн цалин	731,745,300.00	682,294,863.50	49,450,436.50
210102	Нэмэгдэл	449,545,500.00	399,039,674.82	50,505,825.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт		27,198,833.02	-27,198,833.02
210104	Урамшуулал	37,585,500.00	92,875,912.33	-55,290,412.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	152,359,300.00	150,058,854.61	2,300,445.39
210201	Тэтгэврийн даатгал	103,604,500.00	102,081,411.01	1,523,088.99
210202	Тэтгэмжийн даатгал	12,188,700.00	12,000,357.60	188,342.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,094,300.00	5,999,678.80	94,621.20
210204	Ажилгүйдлийн даатгал	6,094,300.00	5,995,141.44	99,158.56
210205	Эрүүл мэндийн даатгал	24,377,500.00	23,982,265.76	395,234.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	174,364,401.75	174,364,401.75	
210301	Гэрэл, цахилгаан	5,430,043.70	5,430,043.70	
210302	Түлш, халаалт	167,935,358.05	168,055,358.05	-120,000.00
210303	Цэвэр, бохир ус	999,000.00	879,000.00	120,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		4,898,500.00	-4,898,500.00
210402	Тээвэр, шатахуун		4,898,500.00	-4,898,500.00
2105	Нормативт зардал	52,058,000.00	52,005,950.00	52,050.00
210502	Хоол, хүнс	52,058,000.00	52,005,950.00	52,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,500,000.00	4,500,000.00	

210604	Урсгал засвар	4,500,000.00	4,500,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,257,300.00	12,266,526.15	6,990,773.85
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,672,100.00	2,278,800.00	2,393,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,585,200.00	9,987,726.15	4,597,473.85
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,209,600.00	66,271,741.00	7,937,859.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	68,411,200.00	61,939,741.00	6,471,459.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,798,400.00	4,332,000.00	1,466,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,657,300.00	110,321,848.25	-67,664,548.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,657,300.00	38,946,750.00	3,710,550.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	42,657,300.00	38,946,750.00	3,710,550.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		71,375,098.25	-71,375,098.25
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		71,375,098.25	-71,375,098.25
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,738,282,201.75	1,776,097,105.43	-37,814,903.68
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		112,983,179.43	-112,983,179.43
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		20,055,774.00	-20,055,774.00

2.6. Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
------------	----------	-----------

I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	178,864,401.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	178,864,401.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	178,864,401.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	174,364,401.75
210301	Гэрэл, цахилгаан	5,430,043.70
210302	Түлш, халаалт	168,055,358.05
210303	Цэвэр, бохир ус	879,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,500,000.00
210604	Урсгал засвар	4,500,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	71,375,098.25
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	71,375,098.25

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 1,377,045.7 мянган төгрөгийн зөрчил илрүүлэн 241,565.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,227.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,133,252.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

3.1 Залруулга: Бараа материалын ангилал хөдөлгөөний бүртгэл буруу хийсэн, үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа оруулаагүйгээс үлдэгдэл өртөг буруу тодорхойлогдсон Үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулаагүй, бараа материалын дансанд 2024 оны эхний үлдэгдэлтэй түлш шатах тослох материалыг тайлант онд зарцуулаагүй эцсийн үлдэгдлээр тайлагнасан, утасгүй интернетийн төлбөрийг бараа материалын тодруулга тайлангийн бусад хангамжийн материалаар тусгаж бараа материалын үлдэгдэл буруу илэрхийлсэн, бараа материалын тайланд барилгын материал үлдэгдлээр тусгагдсан боловч тооллогын бүртгэлээр үлдэгдэлгүй байгаа, өмнөх тайлант үеийн өглөг, авлагын үлдэгдэл тооцоо нийлсэн акт болон хариуцах эзэнгүй буруу тайлагнасан зэрэг 241,565.2 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

3.2 Төлбөрийн акт

Бичиг хэргийн материал, хүнсний материалын үлдэгдлийг тооллогын дүн болон материалын үлдэгдлийн журналтай тулган шалгахад 2,227.7 мянган төгрөгийн материал дутагдуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

3.3 Албан шаардлага өгөгдөөгүй

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын тушаал байхгүй, тайлан, илтгэх хуудасгүй, холбогдох баримт материалыг бүрэн бүрдүүлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлд Тооллогын комисс, түүний эрх, үүрэг, 72.1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь тооллого эхлэхээс өмнө өмч хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий болон холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан Тооллогын комисс томилж байгуулна", 73 дугаар зүйлд Эд хөрөнгийн тооллого явуулах журам 73.1-т "Үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн тооллогоор бэлэн байгаа үлдэгдэл, нягтлан бодох бүртгэлээр байвал зохих үлдэгдлийн хоорондын зөрүүг дор дурдсан журмаар тохируулан тооцно" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," 12 дугаар зүйлийн 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ" гэж заасныг нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хуульд заасны дагуу хагас болон бүтэн жилээр үнэн зөв, бодитоор хийж, холбогдох баримт материалыг бүрэн бүрдүүлж хэвших;

2. Нийцлийн аудиттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны цахим системд 159,897.7 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.4.9-д заасан мэдээллийг энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-тай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим системд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг тухай бүр мэдээлж хэвших;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 25-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингөөс бага байгаа тул “**Өөрчлөлтгүй**” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Бараа материалын ангилал хөдөлгөөний бүртгэл буруу хийсэн	1	74,879.8			1	74,879.8	1	74,879.8				
Үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа оруулаагүйгээс үлдэгдэл өртөг буруу тодорхойлогдсон	1	71,695.7			1	71,695.7	1	71,695.7				
Үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулаагүй	1	48,811.8			1	48,811.8	1	48,811.8				
Бараа материалын дансанд 2024 оны эхний үлдэгдэлтэй түлш шатах тослох материалыг тайлант онд зарцуулаагүй эцсийн үлдэгдлээр тайлагнасан	1	9,225.8			1	9,225.8	1	9,225.8				
Утасгүй интернетийн төлбөрийг бараа материалын тодруулга тайлангийн бусад хангамжийн материалаар тусгаж бараа материалын үлдэгдэл буруу илэрхийлсэн.	1	20,536.0			1	20,536.0	1	20,536.0				

